



**НИЙСЛЭЛИЙН
АХМАДЫН ХОТХОН-1 ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 12 сарын 10 өдөр

Дугаар A/37

Улаанбаатар хот

Хөрөнгө худалдаж авах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2013 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоол, Байгаль орчин аялал жуулчлалын сайд, нийслэлийн Засаг даргын 2018 оны А/226-А/610 дугаартай хамтарсан тушаал, захирамжийн 2 дугаар хавсралт “Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам”-ын 2.1.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам”-ын бүсчлэлийн 1,2 дугаар бүсэд оршин суух ажилчдад зориулж цахилгаан халаалтын төхөөрөмж худалдан авах ажлыг зохион байгуулахыг дулааны инженер /Г.Чулуунбаатар/-т даалгасугай.
2. Бараа материал худалдан авахад шаардагдах 2.035,000 /хоёр сая гучин таван мянга/ төгрөгийг зохих зардлаас гаргахыг Нягтлан бодогч /С.Баяржаргал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОТГОНБАТ

1140300150